**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2026/046/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2026 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цаим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: Ш.Нурлан<br>Утас: 99422966 Цахим хаяг:nurlansh@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .......... 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .......... 3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .......... 8
4.1 Ерөнхий зүйл .......... 11
4.2 Материаллаг байдал .......... 11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .......... 11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .......... 11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .......... 11
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .......... 12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .......... 12
4.5.1 Завсрын аудитын талаар .......... 12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .......... 13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .......... 13
5.1 Төлбөрийн акт .......... 13
5.2 Албан шаардлага .......... 13
5.3 Зөвлөмж .......... 13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .......... 14

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2026.02.18 № 64

танай ____________-ны № ____________-т

ЦЭНГЭЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ГАНБААТАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян Өлгий аймгийн Цэнгэл сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян Өлгий аймгийн Цэнгэл сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Баян Өлгий аймгийн Цэнгэл сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль 2025 онд 2,595.0 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 2,496.3 сая төгрөг зарцуулж, 96.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **152,429,457.3** | **114,789,961.7** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 74,012,165.8 | 44,307,280.9 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 74,012,165.8 | 44,307,280.9 |
| **3121** | **Төгрөг** | 74,012,165.8 | 44,307,280.9 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 74,012,165.8 | 44,307,280.9 |
| **33** | **АВЛАГА** | 500,000.0 | 1,097,001.0 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 500,000.0 | 470,601.0 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 626,400.0 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 77,917,291.5 | 69,385,679.9 |
| **354** | **Хангамжийн материал** | 77,917,291.5 | 69,385,679.9 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | 270,000.0 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,063,440.0 | 5,285,615.0 |
| 35460 | Хүнсний материал | 9,388,000.0 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 64,465,851.5 | 63,830,064.9 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,466,618,575.6** | **4,288,276,007.6** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,466,618,575.6 | 4,288,276,007.6 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,463,212,447.9 | 4,285,225,689.7 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,706,780,638.2 | 4,706,780,638.2 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (639,689,909.5) | (781,496,542.5) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 242,416,737.0 | 280,083,737.0 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (65,010,434.1) | (111,550,649.1) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 237,776,961.7 | 242,476,461.7 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (57,640,221.5) | (90,066,631.7) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 695,071.5 | 695,071.5 |
| 39217 | Ном | 37,883,604.5 | 38,303,604.5 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 3,406,127.7 | 3,050,317.9 |
| 39301 | Програм хангамж | 1,973,239.0 | 1,973,239.0 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (965,111.3) | (1,320,921.1) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,398,000.0 | 2,398,000.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,619,048,032.9** | **4,403,065,969.3** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **1,347,893.0** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 1,347,893.0 |
| **413** | **Өглөг** | - | 1,347,893.0 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 1,347,893.0 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 1,347,893.0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,619,048,032.9** | **4,401,718,076.3** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 4,619,048,032.9 | 4,401,718,076.3 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 733,123,612.0 | 733,123,612.0 |
| 51101 | Өмч: - төрийн | 733,123,612.0 | 733,123,612.0 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,335,812,947.5 | 3,118,482,990.8 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,335,812,947.5 | 3,335,812,947.5 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (217,329,956.6) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 550,111,473.5 | 550,111,473.5 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,619,048,032.9** | **4,403,065,969.3** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,372,562,352.50** | **2,469,072,820.67** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,426,915,452.50** | **2,402,820.67** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,426,915,452.50 | 2,402,820.67 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 2,573,000.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,573,000.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 3,399,483,246.00 | - |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 24,859,206.50 | 2,402,820.67 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,945,646,900.00** | **2,466,670,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,710,157,800.00 | 2,212,786,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,710,157,800.00 | 2,212,786,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 175,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 175,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 235,489,100.00 | 253,709,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 235,489,100.00 | 253,709,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,390,955,535.59** | **2,686,402,777.28** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,390,955,535.59** | **2,686,402,777.28** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,359,383,535.59 | 2,632,970,977.28 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,329,796,897.00 | 1,769,112,160.00 |
| 210101 | Үндсэн цалин | 844,509,501.00 | 1,038,055,496.00 |
| 210102 | Нэмэгдэл | 445,033,796.00 | 664,380,740.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 26,695,000.00 |
| 210104 | Урамшуулал | 40,253,600.00 | 39,980,924.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 166,471,000.00 | 225,345,031.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 113,200,300.00 | 155,712,731.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,317,700.00 | 17,422,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,658,800.00 | 8,711,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,658,800.00 | 8,699,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 26,635,400.00 | 34,799,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 234,436,100.00 | 252,430,493.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,550,951.00 | 20,910,823.00 |
| 210302 | Түлш, халаалт | 209,454,666.00 | 225,048,863.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,430,483.00 | 6,470,807.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 74,190,999.00 | 108,114,354.00 |
| 210502 | Хоол, хүнс | 74,190,999.00 | 108,114,354.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,798,800.00 | 2,001,250.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,798,800.00 | 2,001,250.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,014,194.16 | 20,427,538.99 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 386,200.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 13,627,994.16 | 20,427,538.99 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 538,675,545.43 | 255,540,150.29 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 49,344,661.00 | 26,765,462.30 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,720,100.00 | 6,345,120.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 480,610,784.43 | 222,429,567.99 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 31,572,000.00 | 53,431,800.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 31,572,000.00 | 53,431,800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 31,572,000.00 | 53,431,800.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **2,981,606,816.91** | **(217,329,956.61)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **2,981,606,816.91** | **(217,329,956.61)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,948,219,900.00** | **2,466,670,000.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,573,000.00** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,573,000.00 | - |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2,573,000.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,573,000.00 | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,945,646,900.00** | **2,466,670,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,710,157,800.00 | 2,212,786,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,710,157,800.00 | 2,212,786,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 175,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 175,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 235,489,100.00 | 253,709,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 235,489,100.00 | 253,709,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,914,607,705.16** | **2,452,287,884.99** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,914,607,705.16** | **2,452,287,884.99** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,883,994,505.16** | **2,401,472,084.99** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,330,435,792.00 | 1,769,082,761.00 |
| 210101 | Үндсэн цалин | 845,148,396.00 | 1,038,026,097.00 |
| 210102 | Нэмэгдэл | 445,033,796.00 | 664,380,740.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 26,695,000.00 |
| 210104 | Урамшуулал | 40,253,600.00 | 39,980,924.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 166,471,000.00 | 225,345,031.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 113,200,300.00 | 155,712,731.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,317,700.00 | 17,422,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,658,800.00 | 8,711,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,658,800.00 | 8,699,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 26,635,400.00 | 34,799,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 233,689,100.00 | 251,709,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,550,951.00 | 20,910,823.00 |
| 210302 | Түлш, халаалт | 208,527,666.00 | 224,327,370.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,610,483.00 | 6,470,807.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 77,586,239.00 | 101,342,354.00 |
| 210502 | Хоол, хүнс | 77,586,239.00 | 101,342,354.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,800,000.00 | 2,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,800,000.00 | 2,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,200,994.16 | 19,889,038.99 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,573,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 13,627,994.16 | 19,889,038.99 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 58,811,380.00 | 32,103,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 49,873,680.00 | 25,295,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,937,700.00 | 6,808,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **30,613,200.00** | **50,815,800.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 30,613,200.00 | 50,815,800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 30,613,200.00 | 50,815,800.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **33,612,194.84** | **14,382,115.01** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **546,000.00** | **44,087,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **546,000.00** | **44,087,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 546,000.00 | 44,087,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 546,000.00 | 44,087,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(546,000.00)** | **(44,087,000.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 33,066,194.84 | (29,704,884.99) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 40,945,971.00 | 74,012,165.84 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 74,012,165.84 | 44,307,280.85 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2014 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 733,123,612.00 | 550,111,473.47 | 3,335,812,947.45 | | 4,619,048,032.92 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **733,123,612.00** | **550,111,473.47** | **3,335,812,947.45** | **0.00** | 4,619,048,032.92 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **733,123,612.00** | **550,111,473.47** | **3,335,812,947.45** | **0.00** | 4,619,048,032.92 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **733,123,612.00** | **550,111,473.47** | **3,335,812,947.45** | **0.00** | 4,619,048,032.92 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **733,123,612.00** | **550,111,473.47** | **3,335,812,947.45** | **0.00** | 4,619,048,032.92 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | -217,329,956.61 | | -217,329,956.61 |
| D09 | **20125 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **733,123,612.00** | **550,111,473.47** | **3,118,482,990.84** | **0.00** | 4,401,718,076.31 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,040,495,771.00 | 1,915,153,705.16 | 2,594,582,600.00 | 2,496,374,884.99 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,040,495,771.00 | 1,915,153,705.16 | 2,594,582,600.00 | 2,496,374,884.99 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,999,850,871.00 | 1,884,540,505.16 | 2,540,997,600.00 | 2,445,559,084.99 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,350,533,100.00 | 1,330,435,792.00 | 1,821,148,800.00 | 1,769,082,761.00 |
| 210101 | Үндсэн цалин | 919,693,700.00 | 845,148,396.00 | 1,098,010,000.00 | 1,038,026,097.00 |
| 210102 | Нэмэгдэл | 390,585,800.00 | 445,033,796.00 | 686,950,300.00 | 664,380,740.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | | | 26,695,000.00 |
| 210104 | Урамшуулал | 40,253,600.00 | 40,253,600.00 | 36,188,500.00 | 39,980,924.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 168,816,700.00 | 166,471,000.00 | 245,143,600.00 | 225,345,031.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 114,795,300.00 | 113,200,300.00 | 166,697,800.00 | 155,712,731.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,505,300.00 | 13,317,700.00 | 19,611,500.00 | 17,422,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,752,700.00 | 6,658,800.00 | 9,805,700.00 | 8,711,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,752,700.00 | 6,658,800.00 | 9,805,700.00 | 8,699,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,010,700.00 | 26,635,400.00 | 39,222,900.00 | 34,799,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 285,019,000.00 | 233,689,100.00 | 251,709,000.00 | 251,709,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,516,000.00 | 9,550,951.00 | 15,200,000.00 | 20,910,823.00 |
| 210302 | Түлш, халаалт | 277,003,000.00 | 208,527,666.00 | 227,509,000.00 | 224,327,370.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.00 | 15,610,483.00 | 9,000,000.00 | 6,470,807.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 105,779,700.00 | 77,586,239.00 | 122,046,000.00 | 101,342,354.00 |
| 210502 | Хоол, хүнс | 105,779,700.00 | 77,586,239.00 | 122,046,000.00 | 101,342,354.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,800,000.00 | 1,800,000.00 | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,800,000.00 | 1,800,000.00 | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 21,955,200.00 | 15,200,994.16 | 20,757,200.00 | 19,889,038.99 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,573,000.00 | 1,573,000.00 | 626,400.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 20,382,200.00 | 13,627,994.16 | 20,130,800.00 | 19,889,038.99 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 65,947,171.00 | 59,357,380.00 | 78,193,000.00 | 76,190,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 56,972,771.00 | 50,419,680.00 | 71,230,600.00 | 69,382,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,974,400.00 | 8,937,700.00 | 6,962,400.00 | 6,808,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 40,644,900.00 | 30,613,200.00 | 53,585,000.00 | 50,815,800.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 40,644,900.00 | 30,613,200.00 | 53,585,000.00 | 50,815,800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 40,644,900.00 | 30,613,200.00 | 53,585,000.00 | 50,815,800.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,019,659,065.84 | 1,945,646,900.00 | 2,594,582,600.00 | 2,466,670,000.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,784,169,965.84 | 1,710,157,800.00 | 2,266,349,000.00 | 2,212,961,000.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,784,169,965.84 | 1,710,157,800.00 | 2,266,349,000.00 | 2,212,961,000.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 235,489,100.00 | 235,489,100.00 | 253,709,000.00 | 253,709,000.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 235,489,100.00 | 235,489,100.00 | 253,709,000.00 | 253,709,000.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | - | 74,524,600.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | | 626,400.00 | |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | | | 73,898,200.00 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **40,945,971.00** | | 74,012,165.84 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **74,012,165.84** | | 44,307,280.85 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 70.00 | 70.00 | 71.00 | 70.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 3.00 | 3.00 | 3.00 | 3.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 38.00 | 38.00 | 39.00 | 38.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 29.00 | 29.00 | 29.00 | 29.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **-** | **-** | **71.00** | **70.00** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | | | 39.00 | 38.00 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | | | 1.00 | 1.00 |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | | | 1.00 | 1.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | | | 1.00 | 1.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | | | 29.00 | 29.00 |

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ш.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01 дугаар албан бичгээр 01 дүгээр сарын 22-ны өдөр ирүүлсэн.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,391.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 35.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээлсэн байдлыг шалгаж үзэхэд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 308.0 сая төгрөгийн 1 мэдээлэл, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан 219.5 сая төгрөгийн 2 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 253.7 сая төгрөгний орлогын 7 мөнгөн гүйлгээ, өр, авлагтай холбоотой 1.2 сая төгрөгний 2 мэдээлэл, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл 1 нийт 782.4 сая төгрөгийн 12 мэдээлэлийг мэдээлээгүй байна.Мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 87.5 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4-т "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх", 5 дугаар зүйлийн 5.1.4-т "мэдээллийг тогтмол шинэчилж байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 7 дугаар зүйлийн 7.1-д "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ 7.1.3-т тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

*<u>Шийдвэрлсэн нь:</u>*

Шилэн дансанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 1 мэдээлэл 308.0 сая төгрөг, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан 2 мэдээлэл 219.5 сая төгрөг, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 253.7 сая төгрөгний орлогын 7 мөнгөн гүйлгээ, өр, авлагтай холбоотой 1.2 сая төгрөгний 2 мэдээлэл, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл 1 нийт 782.5 сая төгрөгийн 12 мэдээлэлийг нөхөж байршуулан зөрчлийг арилгах зөвлөмж өгөв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдсөн ба давтан шалгаж үзэхэд хэрэгжүүлсэн байна..

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| **Үзүүлэлт** | **Өмнөх аудитын үзүүлэлт** | | **Биелэлт** | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Зөвлөмж | 1 | 0.0 | 1 | 0.0 | 100.0 |
| **Нийт дүн** | **1** | 0.0 | **1** | 0.0 | **100.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байгаа болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 835.89 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 159.0 сая төгрөгийн алдааг залрууллаа. *Залруулсан алдаа:*

Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөнд нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 0.6 сая төгрөгөөр, улсын төсвөөс санхүүжих эх үүсврийг 53.3 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 0.6 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих 0.5 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 73.9 сая төгрөгөөр дутуу, төсвийн гүйцэтгэлд улсын төсвөөс санхүүжих дүнг 29.8 сая төгөрөөр илүү, туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих 0.2 сая төгрөг дутуу, нийт 159.0 сая төгрөгийн тайлагнасныг залруулав.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-ийн 4.1.3, 5 дугаар зүйл 5.1-ийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Сангийн сайдын 2023 оны А/03 тоот тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" болон УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Аудитаар санхүүгийн асуудалтай холбоотой илэрсэн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Бичигдээгүй.

### 5.2 Албан шаардлага

Бичигдээгүй**.**

### 5.3 Зөвлөмж

***1. Бараа материалын дансны бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

1.1 Илрүүлэлт:

Сургуулийн үдийн хоолны төсвөөр худалдан авсан 53.4 сая төгрөгийн хүнсний материалыг нярвын тайлангаар орлого аваагүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-т “бүх орлого”, “бүх зардал”, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмыг

зөрчсөн байна.

*1.2 Өгсөн зөвлөмж*:

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Үдийн хоолны төсвөөр худалдан авсан хүнсний материалыг нярвын тайлангаар орлого авч, зарлага гаргаж тооцоо хийх, хууль, журмыг мөрдөж ажиллах;

**2.*Батлагдсан орон тооны жишиг нормативын мөрдөлттэй холбоотой асуудал***

2.1.Илрүүлэлт:

Тус сургууль нь 325 сурагчтай бөгөөд Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр хамтарсан тушаалаар баталсан төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны жишиг орон тоонд байхгүй эмчийн 1 орон тоог ажилуулж ирсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр хамтарсан тушаалаар баталсан орон тооны жишиг нормативтай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.3 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр хамтарсан тушаалаар баталсан орон тооны жишиг нормативыг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланг буруу гаргасан | 1 | 159,077.9 | | | 1 | 159,077.9 | 1 | 159,077.9 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | 1 | **159,077.98** | | | 1 | **159,077.9** | 1 | **159,077.9** | | | | |

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** /мянган төгрөгөөр/

<table>
<tr><th rowspan="3">Зөрчлийн товч утга</th><th colspan="2" rowspan="2">Нийт зөрчил</th><th colspan="12">Үүнээс</th></tr>
<tr><th colspan="2">Төлбөрийн акт</th><th colspan="2">Албан шаардлага</th><th colspan="2">Зөвлөмж</th><th colspan="2">Хариуцлага тооцуулах албан шаардлага</th><th colspan="2">Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал</th></tr>
<tr><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Албан тушаалтны тоо</th><th>Тоо</th><th>Дүн</th></tr>
<tr><td>Бараа материалын данстай холбоотой асуудал</td><td>1</td><td>53,431.8</td><td></td><td></td><td></td><td></td><td>1</td><td>53,431.8</td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>Батлагдсан орон тооны нормативын мөрдөлттэй холбоотой асуудал</td><td>1</td><td>0</td><td></td><td></td><td></td><td></td><td>1</td><td>0</td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>Дүн</td><td>2</td><td>53,431.8</td><td></td><td></td><td></td><td></td><td>2</td><td>53,431.8</td><td></td><td></td><td></td><td></td></tr>
</table>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төгрөгөөр/

<table>
<tr><th rowspan="3">Зөрчлийн товч утга</th><th colspan="2" rowspan="2">Нийт зөрчил</th><th colspan="6">Үүнээс</th></tr>
<tr><th colspan="2">Төлбөрийн акт</th><th colspan="2">Албан шаардлага</th><th colspan="2">Зөвлөмж</th></tr>
<tr><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th></tr>
<tr><td colspan="9">Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</td></tr>
<tr><td>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал</td><td>1</td><td>782,467.6</td><td></td><td></td><td></td><td></td><td>1</td><td>782,467.6</td></tr>
<tr><td>Дүн</td><td>1</td><td>782,467.6</td><td></td><td></td><td></td><td></td><td>1</td><td>782,467.6</td></tr>
<tr><td colspan="9">Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>Нийт дүн</td><td>1</td><td>782,467.6</td><td></td><td></td><td></td><td></td><td>1</td><td>782,467.6</td></tr>
</table>